



# АРД ТҮМНИЙ НАМ

## THE POPULAR PARTY OF MONGOLIA

Улаанбаатар хот  
Сүхбаатар дүүрэг, V хороо  
21-р байр -11 тоот  
Утас / Факс: 324844  
e-mail: ardtumninam@yahoo.com

2008.05.15

Улаанбаатар хот

### АРД ТҮМНИЙ НАМЫН 3 ДУГААР БАГА ХУРАЛДАЙН ТОГТООЛ №1

Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1, Ард Түмний Намын дүрмийн 3.1, 22..1.11-р заалтуудыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

**Нэг.** Ард Түмний Намын Бага Хуралдайн гишүүд тэргүүлэгчдийн 100 хувийн саналаар Ард Түмний Нам Монгол Улсын Их Хурлын 2008 оны сонгуульд оролцох болсныг мэдэгдсүгэй.

**Хоёр.** Ард Түмний Намын Улсын Их Хурлын 2008 оны сонгуульд оролцох Мөрийн хөтөлбөрийг хавсралт ёсоор баталсугай.

**Гурав.** Улсын Их Хурлын 2008 оны сонгуульд оролцохыг илэрхийлсэн баримт бичгийг Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн дагуу бүрдүүлж Сонгуулийн Ерөнхий Хороонд хуульд заасан хугацаанд өргөн барихыг тус намын Ерөнхий Нарийн Бичгийн дарга Н.Наранцогтод даалгасугай.

**Дөрөв.** Улсын Их Хурлын 2008 оны сонгуульд Ард Түмний Намаас нэр дэвшигчдийн нэрсийг тодруулан батлахыг тус намын Их Хуралдайд даалгасугай.

Бага Хуралдайн дарга:

Б.Зоригт

Бага Хуралдайн тэргүүлэгчид:

Д.Сүхээ

Л.Эрдэнэ

О.Отгонгэрэл

Х.Оюунцэцэг

Т.Сарангэрэл

Ц.Отгонцэцэг



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2008 ОНЫ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ  
АРД ТҮМНИЙ НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

**1. Бид хэн бэ?**

Бид Ард түмний Нам нь: Ард түмэн - Нийгмийн захиалгын дагуу бий болсон. АТН – Ард түмнийхээ хүсэл, мөрөөдлийн тусгал илэрхийлэл болж, тэднийхээ өргөн дэмжлэг, итгэл сэтгэл дээр тулгуурлан, тэдний сайн сайхны төлөө бүхий л үйл ажиллагаагаа зориулан ард түмнээ хайрлан, ард түмнээрээ хүрээлүүлсэн нам байна. Ард Түмний Нам бол үндэсний эх оронч нам байна. Бид зүүн болон барууны үзлийн дэвшилтэт талуудыг шингээж, Монголын ард түмний сайн сайхны төлөө шаардагдах бүхий л бодлогыг хэрэгжүүлнэ. Хүний эрх, эрх чөлөөг дээдлэхийн зэрэгцээ, хувийн өмч, эдийн засгийн эрх чөлөөг дээд зэргээр хангахын төлөө байна.

**2. Бидний уриа**

**ШИНЭТГЭЛ, ШУДРАГА ЁС, ШИНЭ АМЬДРАЛ**

**Шинэтгэл**- Улс төр, эдийн засаг, оюун санааны шинэтгэл хийнэ.

**Шударга ёс** - Хууль хүн бүрт баян ядуу, жирийн иргэн, эрхдэн дархтан гэлгүй тэгш үйлчилдэг байна. Авилгал хээл хахуул авч, ард түмэн нийгмийн эд баялгийг шамшигдуулан баяжсан этгээдүүдэд хуулийн хатуу хариуцлага тооцоно. Үндэсний баялгийг шударгаар хуваарьлаж хүн бүрт тэгш хүртээнэ. Хүн бүр хүний ёсоор үнэлэгдэж, тэдний олох орлого, өмчлөх өмч, хүрэх эрх мэдэл, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ, хүртэх тусламж, аливаа олдох боломж нөхцлүүд Монгол хүн бүрт нээлттэй, шударга байна.

**Шинэ амьдрал**- Монголчууд хүний дайтай аж төрж, дэлхий нийтийн хөгжил дэвшилтэй хөл нийлүүлэн алхах болно.

**3. Бидний зорилго**

Хүнлэг, иргэнлэг, шударга, ардчилсан, соёлт нийгмийг байгуулна. Гэр бүлийг нийгмийн суурь гэж үзэж дэмжинэ. Хувь хүний хөгжлийг хөхүүлэн дэмжинэ. Баян хоосны эрс ялгааг арилгаж, чинээлэг дундаж давхаргыг бий болгоно.

**4. Бидний тэмцэл**

Ядуурал, ажилгүйдэл, авилгал, хээл хахуул, гэмт хэрэг, нийгмийн бүхий л сөрөг үзэгдлүүд.

**5. Бидний өв**

Их эзэн Чингис хаанаа биширч, Мөнх тэнгэрийн хүчин дор бүх дэлхийн ард түмэн эв найртай амьдрах Чингис хааныхаа бодлогыг уламжилна. Монгол улсын тулгар төрийн баганыг бат бэх түшиж, гал голомтыг нь бадраана. Монгол хэл, зан заншил, уламжлалаа дээдэлж, онгон байгалиа хамгаалж, хайрлан шүтнэ.

## 6. Бидний халамж

Монголчууд үйлдүүд ирдэггүй байх ёсгүй бөгөөд иргэн бүр наад зах нь мөр бүтэн гэдэгс  
Малын, дулаан орон сууцтай байх ёстой. Монголын үрс өлсөж зовж хохирч  
Монголчууд болохгүй бөгөөд хүүхэд төрийн хамгаалалтанд байна. Хүүхдийн мөнгийг  
70.000 болгож цаашид нэмэгдүүлнэ. Өрхийн үйлдвэрлэлийг дэмжиж 5.000.000  
төгрөгийг өрх бүрд нэг удаа олгоно. Нийгмийн эмзэг бүлгийг энэрч халамжилна.  
Малын наядуугаа дэмждэг энэрэнгүй ёс суртахууныг бий болгоно. Эмэгтэйчүүдийн  
нийгэмд эзлэх байр суурь, эрх мэдлийг нэмэгдүүлнэ.

## 7. Баялагийн хуваарьлалт

Өмч хувьчлал, ашигт малтмал, байгалийн баялаг нөөцийг ард түмэнд хишиг  
болгоно. Монголын хот суурин болон хөдөө нутаг дахь газрыг га га-гаар иргэн бүрт  
үнэ төлбөргүй дахин шудрага хуваарьлана. Хот сууринд шилжин ирэгсэд үнэ  
төлбөргүй газар олгоно. Монгол улсын төсөв үрэлгэн оновчгүй байгааг таслан  
зогсоож, жинхэнэ бүтээн байгуулалт хийж төсвийг ард түмэндээ зориулна.

## 8. Бидний боломж

Цалин хөлс, тэтгэвэр тэтгэмжийг Монгол хүн хүний ёсоор амьдарч болох хэмжээнд  
хүргэж цаашид нэмэгдүүлнэ. Оюутнууддаа зориулж орчин үеийн, иж бүрэн оюутны  
хотхонууд / кампус/ байгуулна. Орон сууцыг төрийн хөрөнгөөр бариулж орон сууцны  
эзэл олгож иргэдийг орон сууцаар хангана.

## 9. Бидний төр

Төр нь ард түмнээ хүндэлж, үйлчилдэг ард түмний өмөг түшиг нь байна.

Төрийн хүнд сурлыг арилгана. Амьдралын бүхий л боломжинд хүрэхэд нь иргэдээ  
дэмждэг төр байна.

## 10. Бидний итгэл

Цөөхөн хүн амтай, уудам, онгон нутагтай, агуу их баялагтай, оюунлаг Монголын ард  
түмэн гурван жилийн дотор сайхан амьдралд хүрэх боломж бий.

## 11. Бидний ирээдүй

Эрүүл, боловсролтой, иргэншсэн, зовхи нь өөдөө, баяр баясгалантай Монголчууд

## 12. Бидний хөрш

Хоёр хөрштэйгөө тэгш эрхтэй, харилцан бие биенээ хүндэтгэсэн, найрсаг харилцааг  
дэмжүүлнэ. Гуравдагч хөрш АНУ болон Дэлхийн хамтын нийгэмлэгийн орнуудтай  
бүхий л төрлийн харилцаагаа хөгжүүлнэ.

## 13. Бидний аюулгүй байдал

Монголчуудын үндэсний эрх ашгийг тууштай хамгаална. Монгол хүн бүр эх орон,  
газар шороо, баялагаа эзэмшиж, Монгол газар шороон дээрээ эзний ёсоор тэнүүн  
амьсгалж, эрх чөлөөтэй ажиллаж амьдрана.

**Мөнх тэнгэрийн хүчин дор Монголын үрсийг их эзэн Чингис хаан ивээг.**